



МОНГОЛ УЛС ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 10 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар ...*Засаг*/2333

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.ПҮРЭВДОРЖ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 2 дугаар тогтоол гарч, "Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай" Ерөнхий сайдын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 12 дугаар захирамжийн 1 дэх заалт нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзэн хүчингүй болгосон, "Төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх" шаардлагыг хангаагүй болохыг Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаас шийдвэрлэсэн байхад Л.Ганболдыг Хөвсгөл аймгийн Засаг даргаар дахин хууль зөрчин томилсон шалтгааны талаар тавьсан Таны асуулгын хариуг үүгээр хүргүүлж байна:

1. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны 2018 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтээр "Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай" Ерөнхий сайдын 2016 оны 12 дугаар захирамжийн 1 дэх заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, шударга ёс ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг зөрчсөн гэж дүгнэсэн.

Улсын Их Хурлын 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 25 дугаар тогтоолоор Үндсэн хуулийн цэцийн дээрх дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн боловч Үндсэн хуулийн цэцийн их суудлын 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар уг асуудлыг дахин хэлэлцээд Ерөнхий сайдын 2016 оны 12 дугаар захирамжийн 1 дэх заалт нь Үндсэн хуульд нийцээгүй тул энэхүү захирамжийн холбогдох заалт болон Улсын Их Хурлын 2018 оны 25 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгохоор шийдвэрлэсэн.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4-т "Цэцийн эцсийн шийдвэр гармагц хүчин төгөлдөр болно" гэж, мөн хуулийн 36 дугаар зүйлийн 4-т "Цэцийн эцсийн шийдвэрээр Үндсэн хууль зөрчсөн гэж тогтоогдсон хууль Цэцийн тогтоол гармагц хүчингүй болно." гэж тус тус хуульчилсан. Иймд Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 25 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Ерөнхий сайдын 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 129 дүгээр захирамжаар Ерөнхий сайдын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 12 дугаар захирамжийн 1 дэх заалтыг хүчингүй болгож, энэ асуудал эцэслэн шийдвэрлэгдэж дуусгавар болсон болно.

010032

2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26.2-т “аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад тухайн Хурал дахь нам, эвслийн бүлэг, эсхүл Хурлын төлөөлөгч тус тус нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд уг Хурлын хуралдаанд оролцсон иргэд, төлөөлөгчдийн олонхийн буюу 50-иас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг томилуулахаар томилох эрх бүхий албан тушаалтанд санал болгоно” гэж заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн ээлжит VIII хуралдаанаар Л.Ганболдыг аймгийн Засаг даргад нэр дэвшүүлж, саналаа Монгол Улсын Ерөнхий сайдад албан ёсоор ирүүлсэн.

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дээрх саналыг судлан үзэхэд, Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 1321 дүгээр шийдвэрээр Л.Ганболдыг 2010-2013 онд аймгийн Засаг даргын орон тооны зөвлөхөөр ажиллаж байсныг тогтоосон байх бөгөөд шүүхийн энэхүү шийдвэр нь нэр дэвшигч Л.Ганболд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26.5.2-т заасан Засаг даргад нэр дэвшигч нь “төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх” шаардлагыг хангаж байгааг нотолсон байна.

Иймд Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд дөрвөн жилийн хугацаагаар томилно” гэж заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх тухай” Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоол, Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 1321 дүгээр шийдвэр, Л.Ганболдын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай Авлигатай тэмцэх газрын 2018 оны 01/5933 дугаар албан бичгийг тус тус үндэслэн Лхагвасүрэнгийн Ганболдыг Монгол Улсын Ерөнхий сайд 2018 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 136 дугаар захирамжаар Хөвсгөл аймгийн Засаг даргаар томилсон.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР